



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар СХШ - 2024/14

Сүхбаатар сум

Ерөө сумын иргэдийн Засаг даргын Тамгын
Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн
Хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 10 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2. Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга СХШУАБ Т.Одсүрэн ахлан дотоод аудитор Х.Батбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

1.3. Шалгалтад Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын (цаашид сумын Ерөө сумын ЗДТГ гэх)-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Ерөө сумын ЗДТГ нь улсын бүртгэлийн 3763781 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130255001 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130255408 дугаартай данс болон арилжааны Хаан банк дахь 5679112208, 5679112435 дугаартай дансуудыг ашиглаж байна.

1.5. Ерөө сумын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг сумын ЗДТГ-ын дарга С.Цэвэлмаа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Д.Золзаяа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6. Ерөө сумын ЗДТГ нь улс төрийн албан тушаалтан 4, төрийн захиргааны албан хаагч 12, төрийн үйлчилгээний бусад албан хаагч 4, гэрээт ажилтан 4 нийт 24 хүний орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

4384001125

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

2.1.1 Байгууллагын хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 66.8 хувь, Сэлэнгэ аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 65.2 хувь, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 70.0 хувь, Сэлэнгэ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 71.0 хувь, зарласан жил “Аялал жуулчлал-ногоон хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөг гарган 70.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.1.2 ЗДТГ-ын төсвийн хөрөнгийг зарцуулах захиргааны шийдвэр гаргахдаа Захиргааны актад утга, агуулгын алдаагүй бодит нөхцөл байдлыг тогтоосон эрх зүйн үндэслэл хэсэгт нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэмж хэмжээний актын зүйл заалтыг ашиглахгүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

2.1.3 Сумын ЗДТГ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 оны эхний хагас жилийн байдлаар 5 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,906,122.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,834,499.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,215.5 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт хэмнэлт | Хувь |
|--------|-----------------------------------|-------------|-------------|-----------------|-------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,906,122.0 | 2,614,957.3 | 291,164.8 | 90.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,444,048.0 | 1,336,811.1 | 107,236.8 | 92.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,415,717.8 | 1,292,902.9 | 122,814.9 | 91.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 546,132.8 | 551,537.8 | (5,405.0) | 101.0 |
| 210101 | Үндсэн цалин | 322,349.6 | 258,463.6 | 63,886.0 | 80.2 |

| | | | | | |
|-------------|--|------------------|-----------------|-------------------|-------------|
| 210102 | Нэмэгдэл | 162,657.6 | 194,025.7 | (31,368.2) | 119.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,988.1 | 10,612.2 | 6,375.9 | 62.5 |
| 210104 | Урамшуулал | 26,210.5 | 5,798.6 | 20,411.9 | 22.1 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 17,927.0 | 82,637.7 | (64,710.6) | 461.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 72,307.4 | 67,615.8 | 4,691.6 | 93.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,832.1 | 44,808.0 | 6,024.1 | 88.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,208.7 | 5,702.4 | (493.7) | 109.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,455.1 | 2,850.3 | 1,604.8 | 64.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,073.5 | 2,850.3 | (1,776.8) | 265.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,738.0 | 11,404.8 | (666.8) | 106.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 94,000.0 | 67,017.4 | 26,982.6 | 71.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,314.2 | 28,090.9 | 5,223.3 | 84.3 |
| 210302 | Түлш, халаалт | 60,685.8 | 38,926.5 | 21,759.3 | 64.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 39,230.6 | (39,230.6) | - |
| 210401 | Бичиг хэрэг | 6,411.7 | 2,468.7 | 3,943.0 | 38.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 47,241.7 | 31,431.2 | 15,810.5 | 66.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,530.7 | 3,398.5 | 1,132.2 | 75.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,992.1 | 1,932.3 | 3,059.8 | 38.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 80,045.8 | 18,824.1 | 61,221.8 | 23.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,220.1 | 8,140.0 | 2,080.1 | 79.6 |
| 210602 | Тавилга | 3,122.8 | - | 3,122.8 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 66,702.9 | - | 66,702.9 | - |
| 210604 | Урсгал засвар | - | 10,684.1 | (10,684.1) | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,814.0 | 3,918.0 | 896.0 | 81.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,814.0 | 3,918.0 | 896.0 | 81.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 215,839.9 | 30,909.0 | 184,930.9 | 14.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 214,179.9 | 30,169.0 | 184,010.9 | 14.1 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 692.5 | - | 692.5 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450.0 | - | 450.0 | - |
| 210807 | Газрын төлбөр | 17.7 | - | 17.7 | - |

| | | | | | |
|-------------|---|--------------------|--------------------|----------------------|--------------|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 499.8 | 740.0 | (240.3) | 148.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 339,401.8 | 513,850.2 | (174,448.4) | 151.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 334,061.1 | 511,561.5 | (177,500.4) | 153.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,340.7 | 2,288.7 | 3,052.0 | 42.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 28,330.2 | 43,908.2 | (15,578.1) | 155.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,900.0 | 3,743.7 | 22,156.3 | 14.5 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 2,430.2 | 37,882.1 | (35,451.9) | 1,558.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,430.2 | 2,282.5 | 147.7 | 93.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,462,074.1 | 1,278,146.1 | 183,927.9 | 87.4 |
| 220001 | Барилга байгууламж | 1,211,750.3 | 880,997.7 | 330,752.6 | 72.7 |
| 221001 | Их засвар | 108,036.1 | 307,948.4 | (199,912.4) | 285.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 10,000.0 | (10,000.0) | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 142,287.7 | 79,200.0 | 63,087.7 | 55.7 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,906,122.0 | 2,835,714.8 | 70,407.2 | 97.6 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 2,834,499.3 | (2,834,499.3) | - |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 2,905,702.0 | 2,834,499.3 | 71,202.7 | 97.5 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 420.0 | 1,215.5 | (795.5) | 289.4 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,215.5 | (1,215.5) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 220,757.5 | (220,757.5) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 49.0 | 49.0 | - | 100.0 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 24.0 | 24.0 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 5.0 | 5.0 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.0 | 11.0 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.0 | 4.0 | - | 100.0 |

| | | | | | |
|-----------|---|-------------|-------------|----------|--------------|
| 620004 | Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 | - | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 24.0 | 24.0 | - | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 12.0 | 12.0 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 4.0 | 1.0 | 3.0 | 25.0 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.0 | 4.0 | - | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 4.0 | 4.0 | - | 100.0 |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,614,957.3 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь Орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилтийг 71,202.7 мянган төгрөгөөр дутуу, урсгал зардал 107,236.8 мянган төгрөг, хөрөнгийн зардал 183,927.9 мянган төгрөгийн гүйцэтгэл дутуу болон өөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 795.5 мянган давсантай холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 5,404.9 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 174,448.4 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 15,578.1 мянган төгрөгөөр хэтрүүлж, ажил олгогчийн НДШ-ийн зардлыг 4,691.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,982.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 23,945.5 мянган төгрөгөөр, тавилга эд хогшлын зардлыг 61,221.7 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 896.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 184,930.9 мянган төгрөгөөр хөрөнгийн зардлыг 183,927.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын эдийн засгийн ангиллаар дүн шинжилгээ хийхэд төсвийн төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн, эдийн засгийн ангиллаар үнэн зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

2.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд: Өмнөх оны татан төвлөрүүлсэн 138,766.3 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөөс 2024 А/21 дугаар захирамжаар Үзэсгэлэнгийн худалдаанд оролцогчдын шатахуунд 191.0 мянган төгрөг, А/308 дугаар захирамжаар зураг төсвийн зардалд 20,000.0 мянган төгрөг, сумын ОНХС-аас баяр наадмын зардалд 200,000.0 мянган төгрөг аймгийн Статистикийн хэлтсээс эхний хагас жилийн мал тооллогын зардалд 1,674.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8,554.6 мянган төгрөг зэрэг нийт 369,186.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж 2,14,047.6 мянган төгрөгийг 3 дугаар улирлын байдлаар зарцуулсан байна.

Иргэдтэй хадлангийн газар ашиглуулах гэрээний үндсэн дээр малын өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлсэн боловч санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй, худалдан борлуулсны зарцуулалтын тайлан тооцоог гаргаагүй атал нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Сумын ЗДТГ-ын Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлын тушаал шийдвэр, цагийн тооцоо, цалингийн нэгдсэн систем, холбогдох бусад баримт материалтай тулган шалгахад Цалингийн зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөж урамшуулал, унаа хоол, гэрээт ажилтны цалингийн зардлыг зардлын эдийн засгийн ангиллаар батлаагүй, үндсэн цалин нэмэгдэл цалингийн зардлаар баталснаар төсвийн хуваарь төлөвлөгдөөгүй 59,431.6 мянган төгрөгийн зардлыг гүйцэтгэлээр тайлагнагдсан.

Мөн ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан тушаалд Төрийн үйлчилгээний туслах /жолооч, үйлчлэгч, хэвлэл мэдээллийн ажилтан, жижүүр, цахилгаанчин, сантехникч/ гэсэн албан тушаалын ажил үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхээр баталсан боловч, цалин шинэчлэн тогтоох тушаалд албан тушаалын ангиллыг ТҮ албан хаагчаар баталж тус ангиллын цалингийн сүлжээгээр цалинжуулж орон нутгийн нэмэгдэл болон төрийн алба хаасан нэмэгдлийг олгосон байна.

Албан томилолтоор ажилласан албан хаагчдаас 381.5 мянган төгрөгийг хоолны хөнгөлөлтийг суутган тооцолгүй давхардуулан олгосон байна.

Үндэсний баяр наадам болон сумын 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын бэлтгэл хангахад 16 албан хаагчийг илүү цагаар ажиллуулж 2,523.7 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон байна.

Албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл үр дүнтэй уялдуулалгүйгээр нэгэн адил хувь хэмжээгээр олгосон зөрчил дутагдал хяналт шалгалтын явцад тогтоогдсон байна.

2.4. Орон нутгийн хөрөнгө оруулалт түүний хэрэгжилт үр дүн

Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны төсөвт тусгагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 3,941.808.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл арга хэмжээ батлагдсанаас 3 дугаар улирлын байдлаар бүрэн хэрэгжсэн 275,566.0 мянган төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, дутуу хэрэгжсэн 1,944,77.0 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, огт хэрэгжээгүй 754,448.4 мянган төгрөгийн 7 төсөл арга хэмжээ байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн болон огт хэрэгжээгүй байгаа нь худалдан авах ажиллагааг оройтуулсан, худалдан авах ажиллагааг давтан зарласан боловч оролцогч санал ирүүлээгүй зэргээс голлон шалтгаалсан байна.

2.5. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт 3 дугаар улирлын байдлаар нийт санхүүжилтийн 88.3 хувь буюу 92.7 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь тус журмын 21.1, 2.1.2-т заасан хохирлыг эхний ээлжид санхүүжүүлэхэд нийт батлагдсан хөрөнгийн 30 хувиас доошгүйг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг

сарын хуваариас тооцож нөөцөд бэлэн байршуулсан байх заалтыг зөрчиж 19,184.7 мянган төгрөгөөр нөөц хөрөнгийн үлдэгдлийг хэтрүүлэн зарцуулсан байна.

2.6. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ЗДТГ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх урсгал болон хөрөнгийн зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн тендер шалгаруулалтын журмыг баримтлан зохион байгуулсан байна.

2.7. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Төрийн аудитын байгууллагаас 2024 онд хийсэн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 60,314.3 мянган төгрөг, ОНХС-ийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө сэдэв гүйцэтгэлийн аудитаар илэрсэн 1,238,700.0 мянган төгрөг Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн 496,600.0 мянган төгрөгийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж зөрчлийг арилгасан бол Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар илэрсэн 712,945.3 мянган төгрөгийн зөрчлийн шийдвэрлэлт 60.6 хувтай байна.

2.8 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн боловч үндсэн хөрөнгийн данс бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар аргачлал, бодлогын баримт бичигт тусгасан арга зүйгээр үндсэн хөрөнгийн ангилал, нэршлийг үнэн зөв хөтлөхгүй байгаа нь санхүүгийн тайлан, мэдээлэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна. Иймд дээрх бүртгэлийн алдааг залруулж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.9. Дотоод хяналтын үр нөлөө

Ерөө сумын санхүүгийн албаны 2024 онд хэрэгжүүлэх дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, төрийн сантай холбоотой ажил гүйлгээний чиглэлээр зөвлөн туслах хяналт шалгалтыг 3, 10 дугаар саруудад гүйцэтгэхээр төлөвлөн хэрэгжүүлсэн боловч дотоод хяналтын үр дүн сул байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Ерөө сумын ЗДТГ-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, цалин хөлсний тооцоолол, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл

хөтлөлт, засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй зэрэг дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1. Албан томилолтоор ажилласан албан хаагчдаас **381.5** мянган төгрөгийг хоолны хөнгөлөлтийг суутган тооцолгүй давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Засгийн газрын 2019 оны дугаар тогтоолоор батлагдсан “*Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам*” 2.2 дах “*Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.3 дах “хоолны зардал” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтоор ажилласан албан хаагчдаас хоолны хөнгөлөлтийг суутган тооцож цалингийн зардалд үлдээх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Үндэсний баяр наадам болон сумын 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын бэлтгэл хангахад 16 албан хаагчийг илүү цагаар ажиллуулж **2,523.7** мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “*Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам*”-ын 5-д “*нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахыг хориглоно: 5.1. энэ журмын 4.1-4.4-т заасан тохиолдол*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “*Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл хөлс олгох журам*”-ын 4-д зааснаас бусад тохиолдолд ажил олгогчийн санаачилгаар ажиллуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Засаг даргын нөөц хөрөнгийг 3 дугаар улирлын байдлаар нийт санхүүжилтийн 88.3 хувь буюу 92.7 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь тус журмын 21.1, 2.1.2-т заасан хохирлыг эхний ээлжид санхүүжүүлэхэд нийт батлагдсан хөрөнгийн 30 хувиас доошгүйг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцож нөөцөд бэлэн байршуулсан байх заалтыг зөрчиж **19,184.7** мянган төгрөгөөр нөөц хөрөнгийн үлдэгдлийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам*”-ын 3.4, 3.5, 4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, нөөц хөрөнгийн үлдэгдлийг 30 хувиас доошгүй хувийг бэлэн байршуулж байх шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Иргэдтэй хадлангийн газар ашиглуулах гэрээний үндсэн дээр малын өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлсэн боловч санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй, худалдан борлуулсны зарцуулалтын тайлан тооцоог гаргаагүй атал нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх, 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно."*, 14.4.1 дэх *"аж ахуйн бүх ажил, гүйлгээ"*, 14.4.5 дахь *"бүх орлого"*, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгө материалыг орлогыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Цалингийн зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөж урамшуулал унаа хоол, гэрээт ажилтны цалингийн зардлыг зардлын эдийн засгийн ангиллаар батлаагүй, үндсэн цалин нэмэгдэл цалингийн зардлаар баталснаар төсвийн хуваарь төлөвлөгдөөгүй **59,431.6** мянган төгрөгийн зардлын гүйцэтгэл тайлагнагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх *"... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"*, 22 дугаар 22.1 дэх *"Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана"*, 1 дүгээр зүйлийн 41.2.2 дахь *"Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"*, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт *"Эдийн засгийн ангилал ашиглах заавар"*-ын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төслийг боловсруулахдаа хууль тогтоомжид нийцүүлэн иж бүрэн, үнэн зөв, зардлын эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, батлан хэрэгжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалд Ерөө сумын цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан авахад 16,000.0 мянган төгрөг, ЕБС-ийн хүүхдийн зөвлөлийн өрөөнд компьютер техник хэрэгсэл, тавилга эд хогшил худалдан авахад 15,000.0 мянган төгрөг нийт **31,000.0** мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлуудыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх *"төсвийн хөрөнгө оруулалт"* гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг, 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь *"тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх"*, 6.6.2 дахь *"төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх"* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардалд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, болон тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр

хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх зардлыг тусгахгүй байх шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 7. Бараа материалын 35420 гэсэн дансанд ЗДТГ-ын гадна хашаа болон дээврийн засварт ашигласан 12,716.6 мянган төгрөгийн үнэ бүхий бетон хашаа дээврийн төмрийн зарцуулалтын тайланг гаргаагүй, Кабоны барилгын их засварын 10,000.0 мянган төгрөгийн ажлыг материалыг үлдэгдлээр тайлагнасан, 3 нэр төрлийн 9,235.5 мянган төгрөгийн үнэ бүхий хувцас хэрэглэлийг бөөн дүнгээр тус бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх, 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14.4.1 дэх "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансанд бөөн дүнгээр бүртгэхгүй байх, зарцуулсан бараа материалын үлдэгдлийг бодитоор тайлагнаж байх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 8. Сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан тушаалд Төрийн үйлчилгээний туслах /жолооч, үйлчлэгч, хэвлэл мэдээллийн ажилтан, жижүүр, цахилгаанчин, сантехникч/ гэсэн албан тушаалын ажил үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхээр баталсан боловч, цалин шинэчлэн тогтоох тушаалд албан тушаалын ангиллыг ТҮ албан хаагчаар баталж тус ангиллын цалингийн сүлжээгээр цалинжуулж орон нутгийн нэмэгдэл болон төрийн алба хаасан нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно", 57 дугаар зүйлийн 57.17 дахь "Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно". гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах төрийн үйлчилгээний албан хаагчийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлэхгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 9. Үндсэн хөрөнгийн дансны ангилал болон хөрөнгийн нэршлийг ерөнхий утгаар бүртгэсэн нь өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулж, санхүүгийн тайлан мэдээлэл үнэн зөв илэрхийлэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.: 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн

өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам"-ын 2, дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн дансанд хөрөнгө бүртгэхдээ дансны ангиллын дагуу зөв бүртгэх, хөрөнгийн нэршлийг тодорхой бичиж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Илрүүлэлт 10. Албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл үр дүнтэй уялдуулалгүйгээр нэгэн адил хувь хэмжээгээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн "6.4.1 дэх "Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: албан хаагчдын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажлын гүйцэтгэл үр дүнтэй уялдуулан гүйцэтгэлийн үнэлгээ, хөдөлмөрийн бүтээмжид суурилж урамшууллыг ялгавартай байдлаар олгож байх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 11. ЗДТГ-ын хөрөнгө зарцуулах захиргааны шийдвэр гаргахдаа хууль тогтоомжоор эрх олгосон нарийвчилсан зүйл заалтыг үндэслээгүй байгаа нь Захиргааны процессын хууль зүйн техникийн зөв ашиглаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь "Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой заана" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч нарийвчилсан зохицуулалтай хуулийн заалт, болон хуулиар эрх олгосон захиргааны хэмж хэмжээний актын зүйл заалтыг үндэслэж хууль зүйн техникийн зөв ашиглаж хэвших зөвлөмж хүргүүлэв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Ерөө сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Ерөө сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **173,014.1** мянган төгрөгийн **11** зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 126,281.1 мянган төгрөгийн 6 албан шаардлага, давтан гаргахгүй 46,733.1 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр ирүүлэхийг тус сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД АУДИТОР

 Х.БАТБААТАР

ТАНИЛДСАН.
ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА С.ЦЭВЭЛМАА

НЯГТЛАН БОДОГЧ Д.ЗОЛЗАЯА

